



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс барилга байгууламж хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр шинээр барилга баригдах болсонтой холбогдуулан Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв, Нийслэлийн ерөнхий боловсролын 28 дугаар сургууль, Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн баланст тус тус бүртгэлтэй нийт 1,028,558,725.74 (нэг тэрбум хорин найман сая таван зуун тавин найман мянга долоон зуун хорин таван төгрөг далан дөрвөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад дурдсан 3 барилга байгууламжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1113100175

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 56
дүгээр тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСЛАЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2021.12.31/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн Сүрьеэгийн диспансерын байр	2002	176,472,963.24	17,463,470.38	159,009,492.86	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2022 оны 02-07-091/189 дүгээр дүгнэлт
2	Нийслэлийн ерөнхий боловсролын 28 дугаар сургуулийн хичээлийн I байрны барилга байгууламж	1964	449,081,490.00	303,047,265.11	146,034,224.89	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2021 оны 02-07-111/206 дугаар дүгнэлт
3	Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн гараж, уурын зуух, угаалгын байр, гал тогооны барилга, архивын барилга, агуулах	1980	403,004,272.50	121,810,901.96	281,193,370.54	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02-07-265/08 дугаар дүгнэлт
НИЙТ			1,028,558,725.74	442,321,637.45	586,237,088.29	